

“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК

**“ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



УЛААНБААТАР ХОТ

2026 ОН

**“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”
ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

НЭГ. ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА2 ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1..... Төслийн талбай түүний орчны байгаль орчны төлөв байдал	4
2.2..... Төслийн талбай түүний орчны нийгэм-эдийн засгийн төлөв байдал	5
ГУРАВ . ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3.1.....Гаалийн хяналтын талбайн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	6
3.2...Гаалийн хяналтын талбайн болзошгүй сөрөг нөлөөллийн үргэлжлэх хугацаа, эрчим	7
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	15
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ	17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	10
Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	12
Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15
Хүснэгт 6. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	16
Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	17
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 оны төсөв	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гаалийн хяналтын бүс.....	6
Зураг 2. Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах хэсэг	7

**НЭГ. ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”-ИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

“Эф Би Эл Жи” ХХК-ийн Гаалийн хяналтын бүс төсөл нь Сүмбэр сумын нутаг дахь төмөр замын Чойр өртөөнд байрлана. Аймгийн төв Чойр хот нь Монгол улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт Улаанбаатар хотоос зүүн урагш 250 км зайд оршино.

Гаалийн хяналтын бүс нь Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг, Үйлдвэрлэлийн 115 тоотод орших ба нийт 2.3 га талбайг хамардаг.

Тус гаалийн хяналтын бүс нь Говьсүмбэр аймгийн төвд байрлах тул бүх үйлчилгээндээ ойр, дэд бүтэц сайн хөгжсөн. Цахилгаан эрчим хүчийг төвийн эрчим хүчний системээс хангадаг, зам харилцааны хувьд Улаанбаатар-Чойр-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаар холбогдсон.

Гаалийн хяналтын бүс нь нийт 2.3 га талбайтай бөгөөд 10.0 мян.тн ачаа хадгалах хүчин чадалтай. “Чойр өртөөн дэх гаалийн хяналтын бүс” нь орон нутагт үйл ажиллагаа/төрийн болон хувийн бизнес эрхэлж/ явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд төрийн байгууллагын үйл ажиллагааг тэр дундаа гаалийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй чанартай, түргэн, шуурхай, тасралтгүй хүргэх зорилготой.

Энэхүү төсөл нь орон нутгийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд өөрийн гэсэн хувь нэмэр оруулахын зэрэгцээ нутгийн ард иргэдэд ажлын байр бий болох, түүнийг даган бараа материал эргэлтэнд орж нийгэм-эдийн засагт чухал ач холбогдолтой юм.

Гаалийн хяналтын бүс нь захиргаа, аж ахуйн хэсэг болон технологийн хэсгээс бүрдэх ба захирал, менежер, механик, 3 оператор, 3 харуул, үйлчлэгч нийт 11 ажилчинтай үйл ажиллагаа явуулж байна.

12 вагоны багтаамжтай 372 м урт төмөр зам, ачаа ачиж, буулгах 2.3 га 20-60 см хүртэл зузаантай бүрэн цутгамал бетонон талбай, ачааг жинлэх зориулалттай 150 тн-ын даацтай GCS-U-150 маркийн төмөр замын вагон пүү, 20 м урттай 150 тн-ын даацтай авто пүү болон захиргаа аж ахуйн байр, агуулах зэрэг тоног төхөөрөмжүүдтэй.

“Чойр өртөөн дэх гаалийн хяналтын бүс” төсөлд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2016 онд “Чойбалсангийн охин” ХХК, 2022 онд “Хос нахиа” ХХК-иар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг тус тус хийлгэсэн бөгөөд уг нэмэлт тодотголын үнэлгээний тайланг

**“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”
ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбай түүний орчны байгаль орчны төлөв байдал

Цаг уур, уур амьсгал: Говьсүмбэр орчмын уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Агаарын сарын дундаж температурын агууриг 39.4°C байдаг. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур 18.7°C дулаан, хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -20.7°C хүйтэн байдаг. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 38.6°C хүрч дулаарсан.

Говьсүмбэр орчмоор хойд зүгийн салхи 40.6%, баруун хойд зүгийн салхи 12.1%, өмнө зүгийн салхи 15.0%-ийн давтагдалтайгаар тус тус зонхилон ажиглагддаг байна. Салхины жилийн дундаж хурд 3.2 м/с байна. Салхины хурдны их утга нь хавар, намрын улиралд ажиглагдах бөгөөд 4-5 дугаар сард 4.2-4.4 м/с хүрдэг.

Өвлийн улиралд салхины хурдны бага утга нь ажиглагдана. Салхины хамгийн их хурд 40 м/с хүрч байсан байна. Манай орны бусад нутгийн нэгэн адил хаврын саруудад салхины хамгийн их хурд ажиглагддаг.

Гадаргын болон газрын доорх ус: Гаалийн хяналтын бүс нь аймгийн төвд говь хээрийн бүсэд байрладаг бөгөөд төсөл хэрэгжих талбайн орчинд гадаргын болон гүний ус байхгүй.

Гаалийн хяналтын бүс нь уурын зуухны халаалтын усаа Говьсүмбэр аймгийн “Ус Дулаан” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу ашиглахаас гадна ажилчдын ундны усаа Гүн шанд ХХК-аас баллонтой ус худалдан авч ашигладаг байна.

Хөрсөн бүрхэвч: Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших Гаалийн хяналтын бүсийн 2.3 га талбай судалгаанд хамрагдсан болно. Дээрх талбай нь хөрс газарзүйн мужлалаар Хангайн их мужийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс Бор-Өндөр-Уулбаяны 6-р тойргийн нутагт хамрагдана. [МУ-ын Үндэсний Атлас, 2009].

Хээрийн судалгаагаар гаалийн хяналтын бүсийн талбайн 70 гаруй хувь нь хатуу хучилттай бөгөөд оффис орчмоор ногоон байгууламж байгуулсан байна.

“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС” ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ургамлан нөмрөг: Төсөл хэрэгжих бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евро Азийн хээрийн мужид хамаарна. Бүс нутгийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн.

Гаалийн хяналтын бүс нь Говьсүмбэр аймгийн төвд байрлах учраас төслийн талбайн сул чөлөөтэй талбай бараг ургамлан нөмрөггүй болсон ба зарим газраа маш сийрэг бүрхэвчтэй хөл газрын ургамал ургасан байна.

“Эф Би Эл Жи” ХХК нь өөрийн оффисын барилгын хажуу дахь багахан талбайд мод тарьж ногоон байгууламж байгуулсан байна.

Хяналтын бүсийн барилгажаагүй үлдсэн талбайн 70 гаруй хувийг 20-60 см хүртэл зузаантай бүрэн бетондсон байна. Иймд гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нэмж сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй болно.

Амьтны аймаг: Төсөл хэрэгжих бүс нутаг нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол ойт хээрийн дэд муж, Монгол Дагуурын хээрийн тойрогт хамаарна/А.Г.Банников 1954/.

Төслийн судалгааны талбай нь Говьсүмбэр аймгийн төвд байрлах учраас энд хөхтөн амьтан байхгүй. Гаалийн хяналтын бүс орчимд Монгол улсын болон олон улсын хууль тогтоомж, конвенцуудын хавсралтанд орсон ховор зэрэглэлийн болон агнуурын ач холбогдолтой ан амьтан байхгүй.

2.2. Төслийн талбай түүний орчны нийгэм-эдийн засгийн төлөв байдал

“Эф Би Эл Жи” ХХК-ийн зүгээс тухайн бүс нутагт Гаалийн байгууллагын үйл ажиллагаа үйлчилгээг тухайн бүс нутгийн ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор 2009 оноос хойш Говьсүмбэр аймгийн Төмөр замын Чойр өртөөнд байрлах Төмөр замын салбар зам, ачиж буулгах зориулалт бүхий талбайг Гаалийн байгууллагын тухай хууль Гаалийн хяналтын бүсийн стандартын дагуу барьж байгуулан 2015 оноос бүрэн ашиглалтанд оруулан ажиллаж байна.

Энэхүү ажлыг Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас зохих хяналт шалгалтыг явуулсны үндсэн дээр Гаалийн Ерөнхий газрын 2014 оны 08 дугаар сарын 05-ний өдрийн А/-133 тоот тушаалаар Гаалийн хяналтын бүсээр тогтоосон бөгөөд 2023 онд тус талбайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг дахин сунгасан байна.

**ГУРАВ . ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

3.1. Гаалийн хяналтын талбайн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд

Агаар орчин: “Эф Би Эл Жи” ХХК нь гаалийн бүсдээ жонш, мөнгө, төмрийн хүдэр буулгадаг бөгөөд эдгээр бүтээгдэхүүнүүд нь нүүрснээс даруй 2-10 дахин нягт ихтэй/хүнд жинтэй/ тул тоосжилт, хаягдал бага үүсгэдэг онцлогтой.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих 2.3 га талбайг бетоноор бүрэн хашаажуулсан бөгөөд 1.7 га талбай буюу нийт эзэмшил газрын 70 гаруй хувийг хатуу хучилттай болгосон байна.



Зураг 1. Гаалийн хяналтын бүс



Зураг 2. Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах хэсэг

Газрын гадарга, хэвлий:

Гаалийн хяналтын бүсийн зориулалтаар 2.3 га талбайд газар эзэмших зөвшөөрөл авсан бөгөөд зориулалтын дагуу оффисын байр, агуулах, талбай бусад объектуудыг барьж байгуулсан байна.

Гадаргын болон газрын доорх ус: Гаалийн хяналтын бүс нь аймгийн төвд байрлах ба ойр орчимд гадаргын ус байхгүй. Унд ахуйн усаа худалдааны усаар хангадаг байна. Иймд төслөөс гадаргын усанд ямар нэг нөлөөлөл үзүүлэхгүй.

Ургамлан нөмрөг: Гаалийн хяналтын бүс төсөл нь ачаа хадгалах талбайг бүхэлд нь бетондсон мөн төмөр замаар ачаа тээвэрлэдэг учраас төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт нэмж сөрөг нөлөөлөл бараг үзүүлэхгүй.

Амьтны аймаг: Гаалийн хяналтын бүс нь суурин газар байрлах тул зэрлэг амьтан байхгүй. Иймд Гаалийн хяналтын бүс төслөөс амьтны аймагт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

3.2. Гаалийн хяналтын талбайн болзошгүй сөрөг нөлөөллийн үргэлжлэх хугацаа, эрчим

Шууд нөлөөлөл: Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа харьцангуй тогтворжсон тул цаашид ажиллах явцад байгаль орчинд нөлөөлөх шууд нөлөөлөл нь харьцангуй бага байна. Гэвч өдөр тутмын үйл ажиллагаанаас агаар, хөрсний бохирдол, дуу чимээ үүсэх, иргэдийн орлогын эх үүсвэр бий болох, дэд бүтцийн хөгжилд сайнаар нөлөөлөх, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа зэрэгт шууд эерэг нөлөө үзүүлэхээр харагдаж байна. Мөн байгалийн онцгой аюул

“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС” ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

нөлөөлөх(хүчтэй салхи, үер, газар хөдлөл гм), ХАБЭА-н нөхцөл, дүрэм журам зөрчигдсөнөөс аюул осол гарах зэрэгт шууд нөлөө үзүүлэхээр байна.

Богино хугацааны нөлөөлөл: Байгалийн давагдашгүй хүчин зүйл тулгарах, хөдөлмөрийн эрүүл аюулгүй байдал зөрчигдөж гэнэтийн аюул осол гарсан тохиолдолд богино хугацаанд хүчтэй нөлөөлж болзошгүй. Иймд ажилчдын хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдлыг чандлан сахиж, байгалийн гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Мөн агаарын чанарт үзүүлэх тоосжилт, хөрс бохирдлуулах эх үүсвэр болох хог хаягдал, шатах тослох материалын асуудлаа зөв шийдэж чадвал байгаль орчинд үзүүлэх богино хугацааны нөлөөллүүдийг арилгах боломжтой.

Урт хугацааны нөлөөлөл: Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа цаашид тогтвортой үргэлжилснээр улс орны нийгэм, эдийн засгийн хүчин зүйлст урт хугацааны туршид аажимдаа эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Цаашид гаалийн хяналтын бүс нь үйл ажиллагаа явуулахдаа хөрсний эвдрэл бохирдол, ургамлан нөмрөг доройтох, хөрсний эвдрэл үүсэх зэрэгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулж ажиллавал байгаль орчинд урт хугацаанд үзүүлэх сөрөг нөлөөлөлгүй болно.

Хүчтэй нөлөөлөл: Болзошгүй нөлөөллийн хамгийн хүчтэй байж болох нөлөөлөл нь хүний санамсар болгоомжгүй үйлдэл, байгалийн онцгой үзэгдэл болох шар усны үер, хүчтэй салхи, газар хөдлөл зэргээс шалтгаалж хүчтэй нөлөөлөл үүсч болзошгүй байна.

Дунд зэргийн нөлөөлөл: Орон нутгийн нийгэм эдийн засагт буюу дэд бүтцийн хөгжил, хүн амын орлого нэмэгдэх, орон нутгийн эдийн засагт дунд зэргийн эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна. Харин агаарын бохирдолд өдөр тутмын үйл ажиллагаанаас тоосжилт үүсч дунд зэргийн нөлөөлөл үзүүлэхээр байна.

Бага зэргийн нөлөөлөл: Гаалийн хяналтын бүс нь төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан учир үйлчилгээний салбарын үйл ажиллагаа болон ядуурлыг бууруулахад бага зэрэг эерэг нөлөөг урт хугацаанд үзүүлэхээр байна. Харин хөрсний бохирдол, ургамлын талхагдал зэрэгт бага зэргийн нөлөөлөл үзүүлнэ. Хатуу, шингэн хаягдлаа/тос, тосолгооны материал/ богино хугацаанд зайлуулаагүйгээс хөрс, агаарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй учир хаягдлаа хугацаанд нь зайлуулах, гэрээт байгууллагад нийлүүлэн ажиллах нь зүйтэй.

**“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС”
ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Гаалийн хяналтын бүсийн 2.3 га талбайг бүрэн хашаажуулсан бөгөөд 1.5 га талбайг бараа ачиж, буулгах зориулалтаар 20-60 см хүртэл зузаантай хатуу хучилт хийсэн. Иймд хөрсөн бүрхэвч цаашид элэгдэл эвдрэлд орохгүй, тоосжилт үүсэхгүй нөхцлийг бүрдүүлж байна.

“Эф Би Эл Жи” ХХК нь Гаалийн хяналтын бүсийн ажилчдын ундны усыг цэвэршүүлсэн баллонтой ус худалдан авч хангадаг. Ундны усанд “Гүн шанд” ХХК-ийн цэвэр усны үйлдвэрээс цэвэршүүлсэн ус авч зарцуулдаг. Иймд ус ашиглуулах дүгнэлт гаргуулах болон усны нөөц ашигласны төлбөр төлөхгүй.

Гэвч 2026 онд сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ❖ Хог хаягдлыг удаан хугацаанд хадгалахгүй байх арга хэмжээ авч ажиллах,
- ❖ Болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлж ажиллах
- ❖ Ногоон байгууламжийн арчилгаа тордолт хийх
- ❖ хатуу хучилттай зам талбайн арчилгааг тогтмол хийх

**“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС” ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаар орчин	Гаалийн хяналтын талбайд бараа буулгах, ачих үед тоосжилт, дуу чимээ, хорт хий ялгарах	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэх	Хяналтын талбай болон уурын зуух орчмоос	Удаа	-	1	ОХШ-ий зардал орсон.	2026 онд	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025
2.			Дуу чимээ, тоосжилттой ажлын байран дахь ажилчдад/маск, иж бүрэн хувцас, чихэвч, нүдний шил г.м/хамгаалах хэрэгсэл олгох	Ажилчдад	Удаа	-	-	Байгууллагын дотоод зардлас	2026 онд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага MNS 6768: 2019 Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13994: 2003
3.			Стандартын шаардлага хангасан чанартай түлш хэрэглэх, автомашины түлш шатахууны дутуу шаталтаас агаарт үүсэх хорт хийн ялгаралтыг багасгахын тулд янданд шүүлтүүр суурилуулах, тохиргоо хийх, техникийн нормыг мөрдөх	Төслийн талбайд	Тогтмол	-	-	500.0	2026 онд	Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5010-2001
4.	Усны нөөц,	Эрүүл ахуйн шаардлага	Ажилчдын ундны усанд цэвэр, эрүүл ахуйн	Ажилчдад	-	-	-	480.0	2026 онд	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах

**“ЭФ БИ ЭЛ ЖИ” ХХК-ИЙН ЧОЙР ӨРТӨӨН ДЭХ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС” ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	чанар	хангасан усыг унданд хэрэглэх	шаардлага хангасан ус авч ашиглах							хяналт. MNS 0900:2018
5.	Хөрсөн бүрхэвч	Хог хаягдал болон бохирдуулагч шингэн алдагдсанаас хөрс бохирдох, олон салаа зам үүсэхээс сэргийлэх	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах, оффист ангилан ялгадаг хогийн сав байрлуулах	Оффист	-	-	-	840.0	2026 онд	Ариун цэврийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
6.			Тос тосолгооны материалын хаягдлаар хөрс бохирдуулахгүйн тулд засварын газрыг цементлэж, хатуу хучилттай болгох	Засварын газар	-	-	-	1000.0	2026 онд	Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчны хамгаалах тухай хууль
7.	Биологийн олон янз байдал	Ургамлан нөмрөг нь хүн, техникийн нөлөөгөөр устах, хог хаягдлыг ил задгай хаяснаар мал амьтад хордож болзошгүй.	Эзэмшил тайлбайг цементлэсэн учир шинээр ургамалжуулах талбай байхгүй, харин ногоон байгууламжинд нэмж мод тарих	Оффисын ногоон байгууламж орчимд	-	-		-	Төсөл хэрэгжих хугацаанд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Хог хаягдлын тухай хууль
Төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал, мян.төг								2820.0		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Оффис орчмын ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоог хийнэ	Ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг хийнэ.	Ногоон байгууламж	-	-	-	500.0	Зуны турш	Монгол улсын Ерөнхийлөгчийн 58-р зарлиг, Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2023
2.	Сүмбэр сумын ЗДТГ-аас тогтоосон газарт мод тарих ажлыг зохион байгуулна.	Сүмбэр сумын ЗДТГ-аас тогтоосон газарт мод тарина.	Нийтийн эзэмшлийн талбай	-	-	-	5000.0	Зуны турш	
Нийт							5500.0		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн болон палеонтологийн дурсгал	Эзэмшил талбай нь бүхэлдээ хатуу хучилттай бөгөөд БОННУ-ээр археологийн болон палентологийн дурсгал илрээгүй.	Археологийн дурсгал илэрвэл авран хамгаалах	-	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль Газрын тухай хууль
Нийт зардал						-		

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн хог хаягдал	Гаалийн хяналтын бүсийн ойр орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж байх, сар тутамд их цэвэрлэгээ зохион байгуулах, хог хаягдал гаргасны төлбөр төлөх	Үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	-	-	-	480.0	2026 он	Хог хаягдлын тухай хууль
2.		Төслийн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх	Үйл ажиллагааны явцад	-	-	-	Гэрээний дагуу	2026 он	Хог хаягдлын тухай хууль
3.	Дахин ашиглах	1 удаагийн сав баглаанаас татгалзах, дахин ашиглах боломжтой хогийг өдөрт тутмын хэрэглээнд хэрэглэх, ангилан ялгаж тохижилтод ашиглах	-						
4.	Шингэн хаягдал	Ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдлыг соруулах бохирын цооног орчмыг цементлэн хөрс хамгаалах	Бохирын цооног	-	-	-	1000.0	2026 он	
5.	Аюултай	Ашигласан тос, маслыг ил задгай асгахгүй зориулалтын тусгай саванд хадгалж, Сэлэнгэ аймгийн Морьтон тал ХХК-д гэрээний дагуу нийлүүлэх	Аюултай хог хаягдлын хэмжээнд	-	-	-	-	2026 он	
Нийт зардал							1480.0		

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Байгаль орчны бүрдлүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1	Эзэмшил газрын хөрсний бохирдлыг /эрүүл ахуй, хүнд металл/ хянах	Агрохими	Хог хаягдлын цэг	Хагас жилд 1 удаа	2	50.0	100.0	Итгэмжлэгдсэн лабораториор	Ариун цэврийн тухай хууль Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850 : 2019
2	Хүнд металл, эрүүл ахуй	Хүнд металл, эрүүл ахуй	Барилгажаагүй сул талбай	Хагас жилд 1 удаа	2	50.0	100.0	Итгэмжлэгдсэн лабораториор	
3	Үйл ажиллагааны үед агаарын шинжилгээ	Тоос /PM ₁₀ , PM _{2.5} /, CO ₂ , SO ₂ , NO ₂	Төслийн талбайгаас	Хагас жилд 1 удаа	2	50.0	100.0	Итгэмжлэгдсэн лабораториор	Агаарын чанар Техникийн шаардлага ерөнхий MNS4585:2025
4	хийлгэж нийт тоос, нарийн ширхэгт тоосонцорыг хэмжүүлэх	Уурын зуух орчмоос	Уурын зуух орчмоос	Жилд 1 удаа	1	50.0	50.0	Итгэмжлэгдсэн лабораториор	Агаарын чанар Техникийн шаардлага ерөнхий MNS4585:2025
		Нийт					350.0		

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			сар	сар	сар		
1	2	3	4	5	6	7	
1.	Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, гэрээнүүд/ газар ашиглах, ус ашиглах гэрээ, хог тээвэрлэлтийн гэрээ, ус ашиглах зөвшөөрөл г.м/-ийг цаг хугацаанд нь чанартай биелүүлж дүгнүүлэх, сунгах, холбогдох төлбөр тооцоог хийх	Гэрээний дагуу	5	-	10	Захирал	Байгаль хамгаалах тухай хууль Газрын төлбөрийн тухай хууль Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2.	Ажилтнуудад байгаль орчны болон ХАБЭА-н сургалт ажлын байранд нь зохион байгуулах	800.0	5	-	10	Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
3.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд боловсруулж, батлуулах	-	5	-	10	Захирал	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2019 он
4.	Жонш шуудайлж буй ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	1000.0	5	-	10	Захирал	Хөдөлмөрийн тухай хууль
5.	Ажилчдад болзошгүй аюул ослын үед авах арга хэмжээний талаар сургалтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг тогтмол өгч, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх	-	5	-	10	Захирал	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
Нийт зардал		1800.0					

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Говьсүмбэр аймгийн БОГ	БОМТ-ий тайлан албан бичгээр хүргүүлэх	БОМТ-ий биелэлт	3-р улиралд	50.0	Захирал	Говьсүмбэр аймгийн БОГ
2	Сүмбэр сумын багийн ИНХ	БОМТ-ий тайлан хүргүүлэх	БОМТ-ий биелэлт	3р улиралд	50.0	Захирал	Сүмбэр сумын багийн ИНХ
Нийт					100.0		

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 оны төсөв

№	Зардлын ангилал	Төсөв, мян.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2820.0
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	5500.0
3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1480.0
5.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	350.0
6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1800.0
7.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	100.0
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв, мян.төг		12050.0

“Эф Би Эл Жи” ХХК нь Чойр өртөөн дэх Гаалийн хяналтын бүс төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **12050.0 мянган** төгрөг зарцуулахаар байна.